

## ШИНЭСТ ХК –ийн 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Шинэст ХК нь 2019 оны эхний хагас жил борлуулалтаа нэмэгдүүлж, маркетингаа идэвхижүүлэхээр дараах ажилуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

Үйлдвэрлэл:

1. 2018 онд хатаалгын 1 камерын засварыг бүрэн хийж дууссан байсан бол энэ оны 1-р улиралд хатаалгын 2дахь камерын автомат хаалт, сэнс, хавхлагын моторуудыг сэлбэж, засварласнаас гадна автомат горимд ажиллахад шаардлагатай мэдрэгч, дамжуулагчийг сольж үйл ажиллагааг нь жигдрүүлэн хэвийн ажиллагаанд орууллаа. Ингэснээр хатаах хугацаа 2-3 хоногоор багасч, уурын төлбөрт хэмнэлт гарч эхэлсэн. Мөн хатаах горим хэвийн болсноор хатаах явцад автомат шүршигчүүд сайн ажиллаж модны давирхайг маш сайн угаадаг боллоо.
2. ОХУ-с манай үйлдвэрлэж байгаатай ижил нэрийн их хэмжээний модон бэлдэцүүд хямд үнээр орж ирж байгаа нь манай борлуулалтанд муугаар нөлөөлж байна. Бидний судалснаар гал тогооны тавилга, хаалга, хаалганы бэлдэцийн эрэлт хэрэгцээ их байдаг гэж үзээд дан ганц барилгын модон хийц бус мөн мужаан цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэн өргөтгөж гал тогооны тавилга, хаалга, цонхны бэлдэц хийхээр төлөвлөж эхний ээлжинд мужаан цехийг байгуулахаар үйлдвэрийн шугамаа шинэчилж, үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний хэсэгт мужаан цехийн модон хаалга хийсэн. Энэ хаалга /8ш төмөр рамтай модон хашаа/ дараа дахин ашиглах боломжтой, зөөвөрлөж, борлуулах боломжтой бас нэг бүтээгдэхүүн болж байгаа юм.
3. Үйлдвэрийн түүхий эд тээвэрлэх зорилгоор барьж байгуулсан төмөр замыг Эрэл ХХК тасалж өөрсдийн замд ашигласныг шүүхээр шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргасан нь шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа.

Үйл ажиллагаа:

1. Хаан банкнаас зээлсэн богино хугацаат зээлийг хугацаанд нь төлж барагдуулсан.
2. Мужаан цех болон боловсруулах цехийн өргөтгөл хийх мөн түүхий эд нөөцөлж авах зорилгоор ХХБ-с 500,000,000 төгрөгийн бизнесийн зээлийн 2-р сард авсан.
3. Борлуулалтыг идэвхижүүлэхээр Мишээл Мега Молл ХХК-д павильон түрээсэлж, наамал дүнзэн хаусын материалаар бүрэн тохижуулан ажиллаж байна.
4. 2019 оны 4-р сард Барилга Эм Эн ХХК-с зохион байгуулсан Барилга Экспо-2019 олон улсын барилгын материалын үзэсгэлэнд, 5-р сард зохион байгуулсан орон сууц, хаусын үзэсгэлэнд тус тус амжилттай оролцлоо.

5. Барилга.мн сайтанд гишүүнчлэлээр элссэн.
6. Хангай Зах ХХК-тай мастер гэрээ байгуулж борлуулалтын сувгаа нэмсэн. Хангай зах нь Улаанбаатарт байрлах модны хамгийн том зах бөгөөд Хангай Зах ХХК-иар дамжуулан модон хийцүүдээ борлуулах боломжтой болсон.
7. Эрсдлээс урьдчилан сэргийлж Тэнгэр Даатгал ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгуудаа дараах эрсдлээс хамгаалж даатгууллаа.
  - Гал түймэр, дэлбэрэлт
  - Байгалийн гамшигийн бүх эрсдлүүд
  - Ус чийгний нөлөөллийн эрсдэл
  - Цахилгаан эрчим хүчний эрсдэл
  - Цонхны шилний хохирол
8. Үйлдвэрийн сантехникийн шугамын шинэчлэлийн ажлыг эхлүүлж оффисын дулааны радиатор, дулааны шугамыг бүрэн солиод байна. Үйлдвэр болон оффисын дулааны шугам сүлжээ нь хуучных, дотроо зэвэрч муудсанаас болж өвөлдөө дулааны зардал их гардаг ч хангалттай халааж чаддаггүй байсан. Одоо дулааны зардал буурч, илүү дулаан орчинд ажиллах нөхцөл бүрдэж байна гэж үзэж байна.

Дүгнэлт:

2019 оны эхний хагаст Шинэст ХК-ийн үйл ажиллагаанд тодорхой хэлбэрээр ахиц дэвшил гарсан боловч дараах үндсэн зорилгууддаа хүрч ажиллаж чадаагүй.

Үүнд:

- Төлөвлөсөн борлуулалтын орлого биелэгдээгүй
- үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ажилчдын цалин хөлс, тэтгэмжийг нэмэх
- гадна болон үйлдвэрийн доторх сантехникийн шугамын шинэчлэл

Шалтгаан нь:

Манай борлуулалт жилээс жилд улам багассаар байна. Иймд бид бүтээгдэхүүнийхээ чанарт илүү анхаарч эхэлсэн. Мөн маркетинг, сурталчилгаа сайн хийж, борлуулалтын сувгаа нэмэхээр ажилласаар ирлээ.

Гэвч манай борлуулалтын орлого байгууллагын сарын зардлыг дөнгөж нөхөхүйц зарим өвлийн саруудад зээл болон бусад эх үүсвэрээр нөхөж байгаа нь үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах дорвитой шийдэлийг эрэлхийлсээр байна.

2019 оны 6-р сарын сүүлээр Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн төлөөлөгчид манай үйлдвэрийн барилга болон оффисын барилгыг түрээслэх санал тавьсан. Энэ асуудлаар

ГУЗ хуралдаж түрээслэх гэрээг байгуулахыг зөвшөөрч бид 2019 оны 06-р сарын 24ний өдөр түрээсийн гэрээ байгууллаа. Гэрээ 7-р сарын 1-нээс эхэлж байгаа ч Түрээслэгч байгууллага маань биднийг 7сардаа багтаан нүүхийг зөвшөөрсөн. Одоо бид нүүлгэлт хийх ажилдаа орохоор төлөвлөж байгаа. Нүүлгэлтээс өмнө үйлдвэрлэлтийн шугамаа зогсоохгүйгээр боломжтой хийж болох бүх бүтээгдэхүүнүүдээ хийж нөөцөлж авна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



..... /Д. БАХДАМДЭМБЭРЭЛ/